

## ТАНИЛЦУУЛГА

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”  
Засгийн газрын тогтоолын  
төсөл боловсруулсан тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ” гэж заасан.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн заалтад нийцүүлэн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын 4.9 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын хэлтэс” гэснийг “Нийгмийн даатгалын газар” гэж өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулав.

---oOo---